



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар A/03

Хажуу шинэ ус

2022 оны цэргийн бүртгэл явуулах,  
ажлын хэсэг байгуулах тухай

“Цэргийн албаны тухай хууль”-ийн 4 дүгээр зүйл 4.4 дэхь заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/322 тоот тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэл явуулах журам”, Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн А/03 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2022 оны Цэргийн бүртгэл явуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Н.Өлзийтогтох (ЗДТГ-ын дарга)
Гишүүд	М.Бат-Эрдэнэ (Хэсгийн цагдаа)
	П.Цэцэгмаа (3 дугаар багийн эмч)
	Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Наранбаатар (3 дугаар багийн Засаг дарга)
	Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)
	Д.Бадамбаяр (Сум дундын эмнэлгийн лаборант)
	А.Бямбадорж (Мал эмнэлгийн улсын байцаагч)
	Д.Бадамбаяр (Эрүүл мэндийн төвийн лаборант)
	Т.Цэрэнчунт (ХАА-н мэргэжилтэн)

2.Сумын цэргийн алба хаах насын болон цэргийн бэлтгэл алба хаах насын иргэдийн цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 13, 14-ны өдрүүдэд зохион явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

3.Цэргийн тоо бүртгэл явуулах байрыг Засаг даргын Тамгын газрын иргэний танхимаар тогтоосугай.

4.Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, Коронавируст халдвартар (Ковид-19)-ын тархалтыг хязгаарлах, хавьтлыг бүрэн тогтоох, хянах, тархахаас сэргийлэх зорилгоор гамшигаас хамгаалах арга хэмжээг

хэрэгжүүлж байгаатай холбогдуулан олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан тул ариутгал, халдвартгүйжүүлэлтийн горимыг чанд сахиж улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэртэй нягт уялдуулан бэлтгэл ажлыг ханган олон хүн цуглуулахгүйгээр цэргий тоо бүртгэлийг зохион байгуулсугай.

5.Тоо бүртгэлийн үеэр “Батлан хамгаалах”-ын хууль тогтоомж, цэргийн жинхэнэ болон гэрээт цэргийн албыг сурталчилах сургалт зохион байгуулж, тайланг явуулахыг ажлын хэсэг (Н.Өлзийтогтох)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН

